



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 490

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь Сум дундын Прокурорын газрын балансад бүртгэлтэй, цаашид засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тогтоогдсон нийт 15,628,800.00 (арван таван сая зургаан зуун хорин найман мянга найман зуун) төгрөгийн балансын үнэ, 14,760,534.00 (арван дөрвөн сая долоон зуун жаран мянга таван зуун гучин дөрвөн) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Улсын Ерөнхий Прокурорын газрын туслах прокурор, Тамгын газрын дарга Ц.Арвинбуудай, Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь Сум дундын Прокурорын газрын Ерөнхий прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх Б.Ичинхорол нарт дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай:

2.1.Автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

0002387

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 30 ны өдрийн
190 дугаар тогтоолын хавсралт



НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИН

Д/д	Автомашинь марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон өн	Явсан км	Балансын үнэ	Үлдэгдэл үнэ	Сэргээн босголтын зардал	Худалдах доод үнэ	Дэнчингийн хэмжээ
Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь Сум дундын Прокурорын газрын балансад бүртгэлтэй автомашин								
1	Суудлын автомашин, УАЗ 315122, 67-86 УНС, Арлын дугаар 70586287	2007/2007	хянах эвдэрсэн	15,628,800.00	868,266.00	-	1,500,000.00	375,000.00
				15,628,800.00	868,266.00	-	1,500,000.00	375,000.00
				(арван таван сая зургаан зуун хорин найман мянга найман зуун)	(найман зуун жаран найман мянга хоёр зуун жаран зургаан)	-	(нэг сая таван зуун мянга)	(гурван зуун далан таван мянга)
НИЙТ ДҮН								